



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/11

Сүмбэр сум

Худалдан авах үйл ажиллагааны журам
батлах тухай

Тэрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Шилэн дансны тухай хуулий 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын төсвийн мөнгөн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.
2. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, Хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллахыг худалдан авах ажиллагааны хурлын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЦЭЛМЭГ

2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
даргын *АМ* тоот тушаалын хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ЖУРАМ**



Нэг. Нийтлэгүндэслэл

Улсын бүртгэл, статистикийн газраас бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийхдээ харилцагч байгууллагуудын үнийн саналыг харгалзан чанартай бүтээгдэхүүнийг худалдан авах хуралаар хэлэлцэн шийдвэрлэхэд энэхүү журам үйлчилнэ.

Хоёр. Худалдан авах хуралд оролцох албан хаагч

- Газрын дарга Л. Цэлмэг
- Нягтлан бодогч Ч. Мөнхдалай
- Бичиг хэрэг, нярав П. Насан-Эрдэнэ

Гурав. Худалдан авах шийдвэр гаргах

1. Хоёроос доошгүй үнийн санал авсан байна.
2. Хурлаар үнийн санал, бараа үйлчилгээний хэрэгцээ шаардлага, чанар, төлбөрийн нөхцөл, сонирхолын зөрчил зэргийг хэлцэж худалдан авах байгууллагаа сонгоно.

Дөрөв. Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана.

- Гэрээний үнэ
- Төлбөр хийх нөхцөл, хэлбэр
- Урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн
- Захиалагчийн хяналт болон бусад нөхцөл
- Гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн нөхцөл
- Бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь
- Гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал

Тав. Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох

- Худалдан авах гэрээнд дараах өөрчлөлт хийхийг хориглоно.
- Захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулагатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх
- Гэрээний үнийг нэмэгдүүлэх
- Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Говьсүмбэр Улсын бүртгэл, статистикийн газар